



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/613

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 15 дугаар зүйлийн 15.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 дах заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Ахмад настны асрамж үйлчилгээний төвд гал гарсантай холбогдуулан барилгын засвар, шатсан эд зүйл, зөөлөн эдлэл худалдан авахад шаардагдах зардалд 8,500,000 (найман сая таван зуун мянга) төгрөг, Цэцэрлэг сумын Эрүүл мэндийн төвийн шатахууны зардлын өр барагдуулах зардалд 4,000,000 (Дөрвөн сая) төгрөг, Хөх хотын хараагүйчүүдийн холбооны үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах уулзалтад оролцох иргэн Д.Ганцэцэгт 500,000 (Таван зуун мянга) төгрөг, эмчилгээ хийлгэхэд тусламж хүссэн Мөрөн сумын иргэн Д.Мядагмаад 2,000,000 (Хоёр сая) төгрөг, мөн Арбулаг сумын иргэн Б.Болдбаярт 500,000 (Таван зуун мянга) төгрөг, амьдрах орон гэр болон оюутан хүүхдийн сургалтын төлбөрийн дэмжлэг хүссэн Мөрөн сумын 10 дугаар багийн иргэн Б.Энх-Амгаланд 500,000 (Таван зуун мянга) төгрөг, нийт 16,000,000 (Арван зургаан сая) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2.Дээрх 16,000,000 (Арван зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Э.Анхцэцэг) -д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

